



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (ГНАГ-2024/18-ШТА-ГА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-т хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010392









## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот  
2024 он

ГНАГ-2024/18-ШТА-ГА

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
Нийслэл дэх Төрийн аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс	Хүснэгтийн жагсаалт	3
	Хавсралтын жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4-5
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга:	Бүлэг А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү?	6
 Э.Мөнхмандах		
Аудитын менежер:	А.1 Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан уу?	6-10
 Б.Номинбаатар		
Ахлах аудитор:	А.2 Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?	10-11
 Ж.Жавзанпагма		
Аудитор:	А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?	12-13
 З.Болд		
 Б.Батбилгүүн		
 Г.Саянболд		
	Бүлэг Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан уу?	13
	Б.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?	13-20
	Б.2 Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан уу?	20-22
	Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?	22-23
	БҮЛЭГ В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	24
	В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?	24-25
	В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	25-26
	Аудитын дүгнэлт	27
	Аудитын зөвлөмж	28
	Холбогдох байгууллагын санал	29-31
	Хавсралтууд	32-34

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг,  
Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас:  
327787

Тайланг НТАГ-ын <http://audit.mn/>  
веб сайтаас үзнэ үү.

## Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
МУ	Монгол Улс
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУС	Монгол Улсын сайд
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ННТГ	Нийслэлийн Нийтийн тээврийн газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НУБХТБҮХ	Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах үндэсний хороо
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
СС	Сангийн сайд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБЗАА	Улаанбаатар Захирагчийн ажлын алба
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХС	Эдийн засаг хөгжлийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

Дугаар	Гарчиг	Хуудас
<b>Хүснэгт 1</b>	Төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх	6
<b>Хүснэгт 2</b>	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ-ний мэдээлэл	8
<b>Хүснэгт 3</b>	ТАХ-ний ерөнхий мэдээлэл	10
<b>Хүснэгт 4</b>	Захиалагчийн хяналт	13
<b>Хүснэгт 5</b>	2023 онд хүлээн авсан автобусны мэдээлэл	19
<b>Хүснэгт 6</b>	Нягтлан бодох бүртгэлд туссан эсэх	22
<b>Хүснэгт 7</b>	ТАХ-ний ашиглалтын мэдээлэл	24

Дугаар	Хавсралтын жагсаалт Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Зөрчилтэй ТАХ-ний мэдээлэл	32-34

## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, танилцуулахад аудитын зорилго чиглэлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан уу;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү.

### **Аудитын хамарсан хүрээ**

Аудитаар 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс Нийслэлд эрх шилжүүлсэн, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн Нийслэлийн ЗДТГ, УБЗАА, НХААГ, НХОГ ОНӨААТҮГ, НБГ, НЗХГ, ННТГ, НЭМГ, НӨХГ, СХД-ийн барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ, БНД-ийн ЗДТГ болон холбогдох хэлтэс, алба, ТАХ-г гэрээгээр гүйцэтгэж буй ААНБ, ТАХ-ний үр дүнд бий болсон өмч хөрөнгийг ашиглагч байгууллагуудыг хамрууллаа.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах удирдаж, аудитын менежер Б.Номинбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Жавзанпагма, аудитор З.Болд, Б.Батбилгүүн, Г.Саянболд нар гүйцэтгэв.

**Ерөнхий мэдээлэл:**

2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан ТАХ-нээс 12 ТЕЗ-д хамаарах 886,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 170 ТАХ-г хэрэгжүүлэхээр НЗД-д эрх шилжүүлснээс 802,771.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 154 ТАХ-г 488,347.9 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

Үүний 381,318.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 363,067.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 ТАХ нь шинэ, 504,703.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 163 ТАХ шилжих ажил байна.

ТАХ-г хөрөнгө оруулалтын ангиллаар нь авч үзвэл 95 ТАХ буюу 55.9% нь барилга байгууламж, 40 ТАХ буюу 23.5% нь тоног төхөөрөмж, 33 ТАХ буюу 19.4% нь их засвар, тохижилт, 2 ТАХ буюу 1.2% нь ТЭЗҮ байна.

Нийслэлд эрх шилжсэн ТАХ-г салбараар нь авч үзвэл боловсролын салбарт 60 ТАХ буюу 35.3%, эрүүл мэндийн салбарт 18 ТАХ буюу 10.6%, дэд бүтцийн салбарт 32 ТАХ буюу 18.8%, нийгмийн салбарт 7 ТАХ буюу 4.1%, бусад салбарт 53 ТАХ буюу 31.2% нь хэрэгжсэн байна.

Аудитад төлөвлөлт, санхүүжилт болон өмч ашиглалт, бүртгэлтэй холбоотой асуудлыг 100%, захиалагчийн хяналтын 53.5%-г түүвэрт хамруулсан.

## **А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү?**

Шинээр хэрэгжүүлэхээр 48,523.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөлтийн шаардлага хангаагүй 4 ТАХ-г баталж, гүйцэтгэлд үндэслээгүй 4 ТАХ-нд 3,288.3 сая төгрөгийг илүү олгожээ.

### **А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан уу?**

УИХ-аар 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар шинээр хэрэгжүүлэх 381,318.9, сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-нээс МУС, НУБХТБҮХ-ын даргын багцад баталсан Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-г 2 багцад хувааж нийт 7 ТАХ-г НЗД-д эрх шилжүүлсэн байна.

ТЕЗ-д Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>1</sup>-т заасны дагуу төсөв зарцуулах эрх шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу холбогдох баримт материалыг хавсаргаагүй байна.

Энэ нь тухайн ТАХ-г батлахдаа зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй, тооцоо, судалгаагүйгээр ТАХ-г баталсантай холбоотой байна. Хүснэгтээр харуулбал:

#### **ХҮСНЭГТ№1 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ**

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөв магадлалаар баталгаажсан	Газрын хэмжээ /м2/	Газрын зөвшөөрлийн огноо дугаар	/сая.төг/	
						Ажлын даалгавар Огноо дугаар	албан тушаалтан
1	Багануур хотын ус хангамжийн шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил	2,000.0	2022.02.22 №210/2022	-	-	2023.03.24 АД-08	БНД ЗДТГ-ын дарга
2	Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг нэмэлт ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	1,000.0	байхгүй	байхгүй	байхгүй	2023.08.21 №23/07	УБ хотын ерөнхий менежер бөгөөд ЗАА-ны дарга
3	Нийтийн тээврийн автопаркийн гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	7,626.7	байхгүй	байхгүй	байхгүй	2023.02.02 №2023/07	НХОГ ОНӨААТҮГ-ын дарга
4	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	37,896.4	байхгүй	97349	НЗД-ын 2023.07.05 А/773	2023.02.10 №2023/06	НХОГ ОНӨААТҮГ-ын дарга
		48,523.1					

<sup>1</sup> 14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



Зураг төсөв, газар, техникийн нөхцөл шаардлагатай 48,523.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г төлөвлөлтийн шаардлага хангуулаагүй баталсан, 46,523.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нэг маягийн зургаар батлагдсан ч зураг сүүлийн 2 жилийн хугацаанд магадлал хийгдээгүй байна.

Энэ нь ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасныг зөрчжээ.

Мөн газрын байршил, хэмжээ тодорхойгүй байхад төсөвт өртгийг тооцсон нь төсөвт өртөг бодитой тооцсон эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

2023 оны Төсвийн тухай хууль батлагдахаас өмнө Нийслэлд авто замын түгжрэл бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хийж буй томоохон ажлуудын нэг болох “Нийтийн тээврийн автопаркийн гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ” /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, “Нийтийн тээврийн автопарк” /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний зураг төсөл боловсруулах ажлыг НХОГ ОНӨААТҮГ-т хариуцуулсан байна.

Үүний дагуу НХОГ ОНӨААТҮГ-ын дарга болон Хот байгуулалт судалгааны институт ОНӨААТҮГ-ын дарга нарын хооронд 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн НХОГ/ХТСИ 2022-16 дугаартай 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгөхөөр 29.3 сая төгрөгийн үнийн дүнтэй зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулжээ. Гэрээнд заасны дагуу дараах баримт материалыг хүлээн авахаар гэрээний тусгай нөхцөлд тусгасан. Үүнд:

- Магадлалаар баталгаажсан хяналтын иж бүрэн ажлын зургийг эх хувиар;
- Магадлалаар баталгаажсан хяналтын иж бүрэн төсвийг PDF файл болон EST файлаар CD-д буулгаж;
- Магадлалын ерөнхий дүгнэлт /хавсралтуудын хамт/-эх хувь болон CD-д буулгаж акт үйлдэн хүлээн авч гэрээг 2022 оны 12 дугаар 1-ний өдөр дүгнэхээр байна.

Гэтэл тус гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулаагүй бөгөөд гэрээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, ЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 124 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчиж, 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил буюу 29.3 сая төгрөгтэй ажил дээр шууд гэрээ байгуулсан;
- Магадлалаар баталгаажсан хяналтын иж бүрэн төсвийг PDF файл болон EST файлаар CD-д буулгаж аваагүй;
- Ажлын гүйцэтгэлийг бүрэн хүлээн авч гэрээг 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дүгнээгүй;
- Тус ажлын гүйцэтгэлд олгох 29.3 сая төгрөгийг тухайн ТАХ-ний үндсэн гүйцэтгэгчийн төсөвт өртгийн зураг төсвийн зардлаас гаргуулахаар тооцсон;

Мөн НХОГ ОНӨААТҮГ нь “Нийтийн тээврийн автопарк” ТАХ-ний гүйцэтгэгч “Улз буянт пропертиз” ХХК-ийн ажлын төсөвт өртгийг хянах зорилгоор мэргэжлийн байгууллагаар газар шорооны ажлын тооцоо гаргуулахаар НХОГ ОНӨААТҮГ-ын дарга болон ГЕО ҮНДЭС ХХК-ийн захирал нарын хооронд 2.5 сая төгрөгийн үнийн дүнтэй 01 дугаартай

“Ажил гүйцэтгэх гэрээ”-г 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Тус гэрээтэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

- Гэрээ байгуулахдаа гүйцэтгэгчийг сонгосон шалгуур тодорхойгүй;
- Гэрээт ажлын тайлан нь үндсэн гүйцэтгэгч ААНБ-ын газар шорооны ажлын тайлантай ижил байгаа нь бодитой тооцсон эсэхэд эргэлзээ төрүүлж байна;
- Гэрээт ажлын үндсэн зорилгын дагуу газар шорооны ажлыг үзүүлэлтүүдийг тооцож үзээгүй буюу захиалагч ажлын хэрэгцээнд ашиглаагүй нь үргүй зардал гаргахаар гэрээ байгуулсныг харуулж байна.

НХОГ ОНӨААТҮГ-ын зураг төсөв боловсруулах, ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээнүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн нэг маягийн зурагт дахин төлбөр тооцуулсан болон ажлын гүйцэтгэлийг хянах нэрийдлээр төсвийн хөрөнгийг дур зоргоороо үргүй зарцуулах эрсдэлийг бий болгожээ.

НЗД-ын 2022 оны А/115 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын дүрмийн 4 дэх заалтын 4.1.6-д “Барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар, нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын даалгавар боловсруулах, загвар зураг батлуулах” чиг үүргийг дүрмээр зохицуулсан байхад НХОГ ОНӨААТҮГ нь тухайн чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж байгаа нь дээрх байдалд хүргэж байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г баталснаас төсөвт өртөг нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгожээ.

Нийслэлд шинээр хэрэгжүүлэх 7 ТАХ-нээс 231,961.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

**ХҮСНЭГТ№2 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАХ-НИЙ МЭДЭЭЛЭЛ**

Д/Д	Нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Зохион байгуулагч байгууллага	Шалгарсан ААНБ-ын нэр	/сая төг/ Гэрээ байгуулсан огноо
1	Нийтийн тээврийн автопаркийн гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ / Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	7,626.7	7,626.7	НХААГ	Алтайн үндэс констракшн ХХК	5/18/2023
2	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	37,896.4	37,896.4	НХААГ	Улз Буянт Пропертиз ХХК	4/27/2023
3	Багануур хотын ус хангамжийн шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил	2,000.0	2,000.0	БНД ХААА	Баткомплект ХХК	5/10/2023
4	Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг нэмэлт ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	1,000.0	800.0	НХААГ	Өндрийн удам ХХ	26/11/2023
5	Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/	183,438.6	137,658.7	НХААГ, НЗДТГ	Юутонг бус ХХК	15/12/203
	<b>НИЙТ</b>	<b>231,961.7</b>	<b>185,981.8</b>	-	-	-

Шинээр хэрэгжүүлэх “Нийтийн тээврийн автопарк”-ын барилга барих ТАХ-ний шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичигт тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ТШЗ 17.9-д заасны дагуу санхүүгийн чадавхын мэдээллийг ирүүлээгүй;
- Ижил төстэй ажлын мэдээлэл зөрүүтэй байхад үнэлгээний хорооны гишүүд нягтлан шалгаагүй;

- Тэнүүн Огоо ХХК-ийн 2 болон 3 дугаар баазын барилга хүлээлцсэн акт нь огноо дугааргүй албан ёсны бус барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах акт биш байхад үнэлгээний хорооны гишүүд нягтлан шалгаагүй;
- Тухайн компанийн цахилгааны инженер нь уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт мэргэжилтэй байхад цахилгааны инженертэй дүйцүүлэн тооцсон;
- Ажлын талбайтай танилцсан тэмдэглэл ирүүлээгүй;
- ТШЗ-ны 17.6-д ижил төстэй ажилд нийтийн тээврийн автопаркийн барилгын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно гэж заасан ч Рич мон консалтинг ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын жагсаалтад байхгүй;
- Ижил төстэй ажлын шаардлагыг түншлэгч хангаагүй;
- ТШЗ-ны баримт бичгийн V бүлэгт тендерийн жишиг маягтуудыг баталсан бөгөөд ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээллийг Маягт 6-д зааснаар ирүүлэхээр заасан ч тус маягыг өөрөөр буюу ижил төстэй ажлын төсөвт өртгийн мэдээллийг ирүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Тус ТАХ-ний ХАА-г зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд нь холбогдох заавар журмуудыг мөрдөөгүй, ТББ-т тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.3<sup>2</sup> дахь заалтыг зөрчжээ.

*Иймд “Нийтийн тээврийн автопарк” /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ барих ТАХ-ний тендер зохион байгуулсан үнэлгээний хорооны гишүүдтэй холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой нөхцөл байдал илэрсэн тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу хууль хяналтын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлэхээр Монгол Улсын ерөнхий аудитор хандахаар шийдвэрлэлээ.*

#### **Нийтийн тээврийн автобус ТАХ-ний худалдан авалт:**

Нийтийн тээврийн автобус худалдан авах ажиллагааг ТЕГ-ын 2022 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн №1080 дугаартай “Нийтийн тээврийн шинэ шийдэл төсөл, парк шинэчлэлтийн ажил нь үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой худалдан авах харилцаа байх тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.4<sup>3</sup> дэх заалтын дагуу хэрэгжүүлэх боломжтой” гэсэн албан тоот ирүүлсэн байсан. Харин 2023 онд ТЕГ-аас нийтийн тээврийн парк шинэчлэлийн худалдан авах ажиллагаатай холбоотой албан бичиг ирээгүй байна.

НЗД-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/1620 “Хөрөнгө оруулалтыг зохион байгуулах тухай” захирамжаар “Нийтийн тээврийн автобус” ТАХ-ний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж үр дүнг танилцуулж ажиллахыг НХААГ-ын даргад үүрэг болгосон байна.

НХААГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/157 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар НХААГ-ын 2, НТГ-ын 1, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1, Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбооны 1, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасан байна.

2 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

3 3.4.Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

АТГ-ын 2023 оны 06/15303 дугаар албан бичгийн дагуу “Нийтийн тээврийн автобус” ТАХ-ний тендер сонгон шалгаруулалтын баримт бичгийг НХААГ-ын 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 1/1495 дугаар албан бичгээр эх хувиар нь хүргүүлсэн учир худалдан авах ажиллагааг аудитад хамруулаагүй болно.

**Дүгнэлт:** Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулаагүй байна.

## **А.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?**

2023 онд 886,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 498,888.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 170 ТАХ-г санхүүжүүлэхээр төлөвлөж, 7 төсөл арга хэмжээ хасагдаж, 32 ТАХ өмнөх онуудад хэрэгжиж үнийн индекс тооцуулж, нийт 131 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

### **ХҮСНЭГТ №3 ТАХ-НИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	2023 онд санхүүжүүлсэн дүн
1	Шинэ	7	381,318.9	335,339.0	335,008.2
2	Он дамжих	163	504,703.6	163,549.1	153,339.7
3	Нийт	170	886,022.5	498,888.1	488,347.9

*/сая.төг/*

Эрх шилжин хэрэгжиж буй ТАХ-ээс хугацаа хэтэрсэн, удааширсан 602,911.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ байгаагаас, 72,276.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ нь 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 53,253.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ нь 2018-2020 оноос эхлэн 4-6 жилийн хугацаанд он дамжин хэрэгжиж байгаа ТАХ-үүд байна.

2023 онд НЗД-ын 10 удаагийн захирамжаар 256,303.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 ТАХ-нд материалын үнийн өөрчлөлтийн зөрүү тооцон санхүүжилт олгохоор шийдвэрлэхдээ НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 1,575.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 20,095.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний гүйцэтгэл 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байхад ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг төсөвт тусгаагүй, зөвхөн материалын үнийн зөрүүг тооцож баталсан байна.

НХОГ-аас НЗДТГ-аар дамжуулан ТЕЗ-дад төсөвт суулгуулах хүсэлтээ илгээсэн байна. Тухайлбал:


- 2,064.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/ ТАХ-ний гүйцэтгэл 89%-тай байхад санхүүжих хөрөнгийг төсөвт тусгаагүй. Гүйцэтгэгч: “Энх бизнес өгөөмж” ХХК

**Зураг №1 Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/**



- 2,222.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дугаар хороо/ ТАХ-ний гүйцэтгэл 85.5%-тай байхад санхүүжих хөрөнгийг төсөвт тусгаагүй. Гүйцэтгэгч: Эй Ди констракшн ХХК

**Зураг №2 Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дугаар хороо/**



- 4,297.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний гүйцэтгэл 87%-тай байхад санхүүжих хөрөнгийг төсөвт тусгаагүй. Гүйцэтгэгч: “Биаконэро констракшн” ХХК

**Зураг №3 Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/**



НБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн “Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл шинэчлэл” Багц-1, Багц-2 ТАХ-ний төсөвт өртгийг 2022 оны Төсвийн тухай хуульд 3,000.0 сая төгрөг, 2023 оны төсвийн тухай хуульд 2,369.8 сая төгрөг байхаар тусгасан ч гүйцэтгэгчтэй төсөвт өртгөөс даруй 42.2%-иар бага үнийн дүнгээр буюу 1,369.7 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Анх төсөвт өртөг Төсвийн тухай хуульд тусаж гэрээ байгуулагдах хүртэл ажлын тоо хэмжээ өөрчлөгдөөгүй байхад төсөвт өртөг 42.2%-иар буурч гэрээ байгуулагдсан нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцоогүйг харуулж байна.

2020-2022 онуудад төсөвт тусгагдсан 16,675.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ тайлант хугацаануудад зураг төсөв боловсруулагдаагүй, газрын маргаантай, гэрээ байгуулагдаагүй ажлууд байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 <sup>4</sup>, СС-ын 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналт” журам”-ын 3.2 <sup>5</sup>-т ТАХ-ний төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангаагүй хэвээр байна.

**Дүгнэлт:** Өмнөх оноос шилжин хэрэгжих зарим ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй байна.

<sup>4</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>5</sup> 3.2. Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

### **А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?**

2023 онд 886,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 498,888.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 170 ТАХ-г санхүүжүүлэхээр төлөвлөж 802,771.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 154 ТАХ-нд 488,347.9 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгожээ.

НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 102 ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг тулган баталгаажуулалт хийхэд 12,950.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 ТАХ-нд 2,339.2 сая төгрөг буюу 8%-50%-ийн санхүүжилт, СХД-ийн барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 1 ТАХ-нд 949.1 сая төгрөг буюу 50%-ийн санхүүжилт илүү олгосон байна. Үүнд:

- СХД-ийн барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, Алтай шар говь ХХК-ийн гүйцэтгэж байгаа, Хорооны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо/ барих ТАХ-ний төсөвт магадлал хийж, магадлалаар баталгаажсан дүн буюу 4,768.6 сая төгрөгөөр гэрээг шинэчлэн батлаагүй, төсөвт суугаагүй байхад ТАХ-ний гүйцэтгэлийг төсөвт өртөг, гэрээнд үндэслэхгүй, магадлалд үндэслэн анхны гэрээний дүнгээр бүтэн санхүүжилт олгосон. Гүйцэтгэл 50%-тай байхад 949.1 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон.

**Зураг №4 Хорооны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39,43 дугаар хороо/**



- "Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 43 дугаар хороо/" Гүйцэтгэгч: Их каркас констракшн ХХК, Гэрээний дүн: 2,798.2 сая төгрөг. Ажлын бодит гүйцэтгэл 48%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 98%;
- "Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/" Гүйцэтгэгч: Дарцагт ноёд групп ХХК, Гэрээний дүн: 7,593.9 сая төгрөг. Ажлын бодит гүйцэтгэл 82%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 90%;
- "Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль/" Гүйцэтгэгч: Дарцагт ноёд групп ХХК, Гэрээний дүн: 2,558.3 сая төгрөг. Ажлын бодит гүйцэтгэл 78%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 91%.

НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн "Явган хүний зам, тохижилт" /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 04 сарын 28-ны өдөр НЗДТГ нь "Нобле Роуд" ХХК-тай байгуулжээ. Тус гэрээнд техник хяналтыг зардлыг 17,131.7 мянган төгрөгөөр заасан ч НХОГ ОНӨААТҮГ нь техникийн хяналтын зардалд 22,581.7 мянган төгрөгийн зардлыг суутган авсан байна.

НХОГ ОНӨААТҮГ-аас техник хяналтыг буруу тооцож гэрээнд тусгасан тухай мэдээлэл өгсөн хэдий ч гэрээг өөрчлөх буюу техникийн хяналтыг зардлыг нэмэгдүүлэх тухай холбогдох баримт бичгийг НЗДТГ-т хүргүүлээгүй байна.

**Дүгнэлт:** ТАХ-ний зарим санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслээгүй 3,288.3 сая төгрөгийг илүү олгожээ.

**Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан уу?**

Нийслэлд эрх шилжсэн 170 ТАХ-ээс 81 ТАХ буюу 47.6% нь дууссан үүнээс 32 ТАХ 2021-2022 онд хэрэгжиж 2023 онд үнийн индекс тооцуулсан, 39 ТАХ буюу 23% нь хугацаандаа хэрэгжиж, 40 ТАХ буюу 23.5% нь хугацаа хэтэрч, 3 ТАХ буюу 1.8% нь удааширсан, 7 ТАХ буюу 4.1% нь гэрээ цуцлагдсан, хөрөнгө татагдсан болон бусад шалтгаанаар хэрэгжээгүй байна.

**Б.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?**

Эрх шилжсэн ТАХ-нээс материалын үнийн зөрүү тооцуулсан болон хэрэгжээгүй 39 ТАХ-ээс бусад 131 ТАХ-нд УБЗАА, НБГ, НЗХГ, ННТГ, НӨХГ, НХОГ ОНӨААТҮГ, НЭМГ, СХД-ийн барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-д захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын түүвэрт 425,149.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 ТАХ буюу нийт ТАХ-ний 69.4%-ийг хамруулан ТАХ-г г төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг тодруулахад 30 ТАХ буюу 33%-д нь зураг, төсөвтэй холбоотой 43, техникийн шаардлагатай холбоотой 19 зөрчил илэрлээ.

*ХҮСНЭГТ№4 ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ*

Д/д	Захиалагчийн хяналт	Зөрчилтэй ТАХ-ний тоо	Зураг, төсөвтэй холбоотой зөрчил	Техникийн шаардлагатай холбоотой зөрчил
1	НЗХГ	5	10	0
2	ННТГ	1	0	19
3	НХОГ	23	30	0
4	СХД	1	3	0
	<i>Нийт</i>	30	43	19

Илэрсэн зөрчлөөс дурдвал:


- НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 5,762.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Солид констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал” /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/ барилгын хана цууралт өгсөн, сан техникийн ажил дутуу хийгдсэн, спорт заалны сагсан бөмбөгийн бэхэлгээ салсан, спорт заалны дээд давхрын гарцын хаалгыг хөөсөөр нааж тогтоосон, цонх дулаан алдалттай, анги болон коридоруудын шалны тэгш хэм өөрөөс шалтгаалан ам дарагч тогтдоггүй, төв хаалганы дотор хаалга бэхэлгээ муутай, савладаг, В1 давхрын сүлжээний салаалагч төхөөрөмжгүй, цахилгааны залгуур хийгээгүй, ханын хөвөө салж, унасан, ангиудын цахилгааны залгуур тэгш бус хэмжээнд суурилагдсан, шүршүүрийн тэгш хэм алдаатайгаас ус алддаг.

**Зураг №5 Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/**



- НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 967.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Цагаан толгойн нуур” ХХК-ийн гүйцэтгэсэн БГД-ийн 17-р хороонд хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлын зургийг зохиогчтой зөвшилцөөгүй, СӨХ-ны саналаар өөрчилсөн;

**Зураг №6 Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг/**



- НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 2,558.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дарцагт ноёд групп “ХХК-ийн гүйцэтгэсэн “Сургуулийн барилгын өргөтгөл” /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 31 дүгээр сургууль/ ТАХ-г гүйцэтгэх явцад дээвэр хуулснаас шалтгаалан сургуулийн 1, 2 дугаар давхар борооны усанд автаж, чийгтэж, мөөгөнцөртсөн. Ус алдсаны дараагаар гүйцэтгэгч компани засварын ажлыг хийж гүйцэтгэсэн ч дээврийн усны хаялга, барилгын агааржуулалтын хоолойг хийгээгүй, давхруудын хана, хаалгыг будаагүй байна. Сургуулийн захиргаанаас холбогдох газруудад удаа дараа гомдол, санал гаргасан хэдий ч НХОГ-аас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.





- НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 11,608.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй авто болон явган хүний зам тавих 5 ТАХ-ний үр дүнд баригдсан замын бродюр үйрч бутарсан, газар чөлөөлөлт дутуу хийгдсэнээс ажил удааширсан, гүйцэтгэл дутуу.

Зураг №8 НЗХГ-аас хяналт хэрэгжүүлсэн ТАХ-үүд



НЗД-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/1620 дугаар “Хөрөнгө оруулалтыг зохион байгуулах тухай” захирамжаар захиалагчийн хяналт тавьж ажиллах чиг үүргийг Нийслэлийн НТГ-ын даргад өгсөн. Үүний дагуу ННТГ-ын даргын 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/65 дугаар “Автобус хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсгийг ННТГ-аас 9, НЗДТГ-ын Тээвэр төлөвлөлтийн хэлтсийн 1, ХСХГ-ын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн 1, НӨХГ-ын Өмчийн бүртгэл мэдээллийн хэлтэс 1, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын Техникийн хэлтсийн 1, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын Техник, технологийн хэлтсийн 1, Тэнүүн огоо ХХК-ийн 1 албан хаагчдаар бүрдүүлсэн байна.







НЗДТГ, Тэнүүн-Огоо ХХК-ийн хооронд 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлэхээр 317,949.3 сая төгрөгийн үнийн дүнтэй ННТГ23001, ННТГ23001-01 дугаартай гэрээг байгуулж, нийт 810 автобус, цахилгаан автобусны 41 цэнэглэгчийг техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлэхээр тусгасан байна.

Гэрээний дагуу 2023 онд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобуснаас 20 буюу 3.3%, их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 160 автобуснаас 55 буюу 34.4%, дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй 50 автобус 100%, цахилгаан автобусны 41 цэнэглэгч нийлүүлэхээс 10 буюу 21.7% нь тус тус нийлүүлэгдсэн байна.

ННТГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 318,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Гүйцэтгэгч: “Тэнүүн-Огоо” ХХК Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн нийтийн тээврийн их багтаамжийн цахилгаан болон дизель,

дунд багтаамжийн дизель автобусыг техникийн тодорхойлолтод нийцсэн эсэхийг тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Д/д	Их багтаамжийн дизель автобус	Их багтаамжийн цахилгаан автобус	Дунд багтаамжийн автобусны үзүүлэлт
1			
	<p>Тэргэнцэртэй иргэнд зориулсан зориулалтын хэсэггүй.</p>	<p>.</p>	<p>Тэргэнцэртэй иргэнд зориулсан зай талбай байхгүй. "Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022-ын 6.7 заалтыг үндэслэн техникийн үзүүлэлтэд тэргэнцэртэй иргэний зорчих зайг тусгаагүй.</p>
2			
	<p>"Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022-ын 6.6 заалтад тэргэнцэртэй зорчигч бусдын тусламжгүйгээр зорчих боломжтой байх, тавцангийн налуу 12 градусаас ихгүй байх заалттай ч техникийн үзүүлэлтэд тусгаагүй, тэргэнцэртэй зорчигч бусдын тусламжгүйгээр зорчих нөхцөл хангагдаагүй, тавцангийн налуу 12 градусаас их.</p>	<p>"Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022-ын 6.6 заалтад тэргэнцэртэй зорчигч бусдын тусламжгүйгээр зорчих боломжтой байх, тавцангийн налуу 12 градусаас ихгүй байх заалттай ч техникийн үзүүлэлтэд тусгаагүй, тэргэнцэртэй зорчигч бусдын тусламжгүйгээр зорчих нөхцөл хангагдаагүй, тавцангийн налуу 12 градусаас их.</p>	<p>"Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022-ын 6.6 заалтад тэргэнцэртэй зорчигч бусдын тусламжгүйгээр зорчих боломжтой байх, тавцангийн налуу 12 градусаас ихгүй байх заалттай ч техникийн үзүүлэлтэд тусгаагүй, комиссын хүлээн авсан автобусанд тэргэнцэртэй иргэн зорчих тавцан байхгүй.</p>
3	<p>Техникийн үзүүлэлтэд хажуу шил нь бууралттай, давхар байна гэж заасан ч нийлүүлсэн автобус дан, бууралтгүй шилтэй.</p>		<p>Техникийн үзүүлэлтэд хажуу шил нь бууралттай, давхар байна гэж заасан ч нийлүүлсэн автобус дан, бууралтгүй шилтэй.</p>

4	<p>Техникийн үзүүлэлтэд хаалга бүрийн гадна талд гэрэлтүүлэгтэй байна гэж заасан ч нийлүүлсэн автобус нь гэрэлгүй.</p>		<p>Техникийн үзүүлэлтэд хаалга бүрийн гадна талд гэрэлтүүлэгтэй байна гэж заасан ч нийлүүлсэн автобус нь гэрэлгүй.</p>
5			 <p>Техникийн үзүүлэлтэд жолоочийн хэсэг бүхээгтэй байна гэж заасан ч нийлүүлсэн автобус бүхээгийн хэсэггүй.</p>
6			 <p>Техникийн үзүүлэлтэд орох гарах гишгүүр болон шалны өндөр 30см-ээс ихгүй байна гэж заасан ч хүлээн авсан автобус 31 см өндөртэй.</p>
7	<p>Техникийн үзүүлэлтэд зорчигчдын суудал бүрд гар утас болон нэмэлт төхөөрөмж цэнэглэх USB байршуулсан байна гэж заасан ч хүлээн авсан автобусанд байхгүй.</p>		
8	<p>Босоо зорчигчдын тоо 40-өөс дээш гэж заасан ч 24 зорчигч зосгох зориулалттай</p>		<p>Техникийн үзүүлэлтэд 18-аас дээш суудалтай байна гэж заасан нь "Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022 стандартад дунд оврын автобус 20-26 хүний суудалтай байна гэж заасантай нийцээгүй.</p>
9	<p>Зорчигчдын зааланд 6-аас доошгүй халаалтын төхөөрөмжтэй байна гэж заасан ч зааланд 2 халаагч дутаа байрлуулсан.</p>		

10			Техникийн үзүүлэлтэд зорчигчийн бариулын өндөр шалнаас дээш стандартад нийцсэн байна гэж заасан, "Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022 стандартын 6.4-т заасан хүүхэд, намхан нуруутай зорчигчдод зориулсан намсгасан нэмэлт бариул байршуулаагүй.
11	Техникийн үзүүлэлтэд заасан камер болон түүнийг хянах системгүй.		Техникийн үзүүлэлтэд заасан чанга яригч, нийтийн тээврийн чиглэлийн дугаар, хаяг бүхий цахим дэлгэцгүй, камер болон түүнийг хянах системгүй.
12	Техникийн үзүүлэлтэд жолоочийн суудал сайжруулсан савхин материалаар хийгдсэн байна гэж заасан ч даавуун суудалтай.		
13	Техникийн үзүүлэлтэд нэмэлтээр шаардсан мөнгөний хайрцаг, хогийн сав байхгүй.		

Мөн БНХАУ-д үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын LMEBEG1R6PE000178 арлын дугаартай 2 автобус тээвэрлэх явцад гэмтсэн ч шаардлагад нийцсэн гэж үнэлэн өнөөдрийг хүртэл завсарлаагүй, захиалагчид хүлээлгэн өгөөгүй байна.

Зураг №9 Автобусны зураг



**Санхүүжилт:**

ННТГ23001, ННТГ23001-01 дугаартай гэрээний 7.1 -д заасны дагуу 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдөр 81,666.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг СЯ-наас Нийслэлийн төрийн сангийн дансаар дамжуулан гүйцэтгэгчийн дансанд шилжүүлж, 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд 4 удаагийн хүсэлтээр Тэнүүн-Огоо ХХК-ийн нийлүүлсэн 125 автобус, 10 цэнэглэгч хүлээн авч 134,561.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 2023 онд санхүүжих дүнгийн 49.4% нь байна.

**ХҮСНЭГТ№5 2023 ОНД ХҮЛЭЭН АВСАН АВТОБУСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Д/д	Нийлүүлэх автобус	Нийт тоо ширхэг	Хүлээж авсан	Нэгж үнэ	/сая.төг/ Нийт үнэ
1	Их багтаамжийн цахилгаан автобус	160	55	625.5	100,079.0
2	Их багтаамжийн дизель автобус	600	20	339.7	203,787.9
3	Дунд багтаамжийн автобус	50	50	218.6	10,931.8
4	Цахилгаан цэнэглэгч	41	10	76.8	3,150.5
<b>ДҮН</b>		<b>851</b>	<b>135</b>	<b>-</b>	<b>317,949.3</b>

ННТГ-ын 2023 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн санхүүжилт хүсэх тухай 01/06/1627 дугаартай албан бичгийн хүсэлтийн дагуу НЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь 2023 оны 6 дугаар сард БНСУ-ын “HYUNDAI BUS” ХХК-д үйлдвэрлэсэн “HYUNDAI CS-COUNTRY” загварын 50 ширхэг дизель хөдөлгүүртэй дунд багтаамжтай автобусны үнэ 10,931.8 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээх хүсэлтийг 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/5350 албан бичгийг СЯ-нд хүргүүлсний дагуу 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр гүйцэтгэгчийн дансанд шилжүүлсэн байна. Дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус нь дараах зөрчилтэй байхад санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- НИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 24 дүгээр “Зорчигч тээврийн үйлчилгээнд хамаарах хотын стандартыг батлах тухай” тогтоолоор батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS 1603B:2022” стандартын дунд багтаамжийн нийтийн тээврийн стандартад нийцээгүй;
- Техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангаагүй;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.13-т “Авто тээврийн тухай хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн үйлчилгээ” албан татвараас чөлөөлнө гэж заасан шаардлагад нийцээгүй нийтийн тээврийн хэрэгсэл тул татвар ногдуулсан ч төлөөгүй;

Гэтэл 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр ажлын хэсэг нь Улаанбаатар хот дахь Гаалийн баталгаат агуулахын хашаанд байгаа автобусыг техникийн шаардлагад бүрэн нийцсэн гэж дүгнэлт гаргажээ.

НЗД-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/160 дугаар захирамжаар ТАХ-ний гүйцэтгэлээр санхүүжилтийн эрхийг нээхийг ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст үүрэг болгосон ч гүйцэтгэлийг хянахдаа баримт бичгийн бүрдлийн хүрээнд хянаж санхүүжилтийг олгожээ.

ННТГ-аас тус нийтийн тээврийн автобусанд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх саналтай байна.

Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалтын БНБД 12-01-09-ийн 5.1-т “Барилгын үйлдвэрлэлийн бэлтгэл ажилд дараах ажлууд хамаарна, ...газрын зөвшөөрөл авах, баригдах барилга байгууламжийн холбох техникийн нөхцөл авах” гэж заасныг баримтлалгүйгээр бэлтгэл ажил хангагдаагүй ТАХ-г дахин төлөвлөж байгаа нь төсвийн хөрөнгө ашиглагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал:

- НЗХГ-аас хяналт хэрэгжүүлсэн 1,977.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн соёлын төв дагуух хатуу хучилттай авто зам, 1.6 км” /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/ ТАХ нь 2020 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд газар бүрэн чөлөөлөгдөөгүйн улмаас ажил зогссон. Гүйцэтгэгч: “Баян-Өлзийт зам” ХХК

- НХОГ-аас хяналт хэрэгжүүлж байгаа 8,576.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор” /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/ ТАХ нь 2021 оноос эхлэн хэрэгжиж байгаа хэдий ч газар чөлөөлөлт бүрэн дуусаагүйн улмаас хугацаа хэтэрсэн байна. Гүйцэтгэгч: “Аглут” ХХК

Зураг №10 Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/

2022 оны 3 дугаар сар



2023 оны 3 дугаар сар



2024 оны 3 дугаар сар



**Дүгнэлт:** Түүвэрт хамрагдсан 91 ТАХ-ээс 30 ТАХ буюу 32.9% нь зураг, төсөв техникийн шаардлагын дагуу хийгдээгүй байна.

## **Б.2. Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан уу?**

Нийслэлд эрх шилжсэн ТАХ-ний 65.3%-д нь НХОГ ОНӨААТҮГ, 34.7%-д нь бусад байгууллагаас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

Эрх шилжсэн 170 ТАХ-нээс үнийн индекс тооцуулсан болон хэрэгжээгүй 39 ТАХ-нээс бусад 131 ТАХ буюу 77%-д нь холбогдох байгууллагуудаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

ЗТХС-ын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх” журмын 1.2-т “Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээг заавал хэрэгжүүлэх бөгөөд энэхүү журмыг баримтална” гэж заажээ.

Гэтэл НЗД-ын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/509 дүгээр захирамжаар “Нийслэлийн Замын хөгжлийн газар”-ын дүрмийг баталж, 4.1<sup>6</sup>-ийн 4.1.3-д “улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөх шинэчлэх, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулан, захиалагчийн болон лабораторийн хяналт тавих” гэж заасны дагуу НЗХГ нь авто замын ажилд хяналт хэрэгжүүлж ажиллахдаа зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэлгүйгээр захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн нь дээрх журмын заалттай нийцэхгүй байна.

НХОГ ОНӨААТҮГ-аас 3,447.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй БГД, СБД-үүдэд хэрэгжих буй авто зам барих болон засварлах 3 ТАХ-нд авто замын инженертэй гэрээ байгуулан захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

НЗХГ, ННТГ, НХОГ ОНӨААТҮГ, СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ, УБЗАА-уудаас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ-тэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

### **Нийслэлийн Замын хөгжлийн газар:**

<sup>6</sup> Дөрөв. Газрын үндсэн чиг үүрэг. 4.1. Газар дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Аудитын түүвэрт хамрагдсан 7,353.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талбайн журнал хөтлөөгүй, хяналт хэрэгжүүлсэн бичвэр тэмдэглэгээг ажлын талбарт үйлдээгүй;
- Гүйцэтгэгч ажил хүлээлгэн өгөх хүсэлт өгч урьдчилсан комисс ажиллаж комиссоос үүрэг даалгавар өгсөн ч гүйцэтгэлийг хангуулж ажил хүлээлцээгүй 1 жил үргэлжилсэн;
- Гол болон туслах замтай холбогдохооргүй гудамж дунд зам барих ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байхад мэргэжлийн бус хандаж, үр дүнгүй хөрөнгө оруулалтыг дэмжсэн байна.

Нийслэлд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто замын барилга байгууламж, засварын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг тодорхой болгож нэг байгууллагад хариуцуулах, журамд заасны дагуу зөвлөх үйлчилгээ авч хяналт хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

### **НХОГ ОНӨААТҮГ:**

ТАХ-ний 65.3%-д нь захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Хяналт хэрэгжүүлсэн 23 ТАХ нь гүйцэтгэлээс давуулж санхүүжилт олгосон, зурагт төсөвт зохиогчтой зөвшилцөөгүй өөрчлөлт оруулсан, шаардлага хангаагүй ТАХ-ний гүйцэтгэлийг комисс ажиллаж хүлээн авсан, норм дүрэм, стандартын дагуу гүйцэтгээгүй ажилд явцын санхүүжилтийг олгосон;
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ТАХ-ний гэрээний үргийн биелэлтийг хангуулаагүй;
- Барилга байгууламжийн улаан дэвтрийн хөтлөлтийг удаа дараа шаардсан боловч архивд хүлээлгэн өгсөн болон гүйцэтгэгчид байгаа шалтгаанаар өгөөгүй аудитын үйл ажиллагаанд саад учруулсан.

### **СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ:**

СХД-ийн захиалагчийн хяналтын алба ОНӨААТҮГ нь 2023 онд 13 ТАХ эрх шилжин ирснээс 3 ТАХ-ний гүйцэтгэгч шалгараагүй, үнийн индекс тооцуулсан шалтгаанаар хэрэгжээгүй, харин 10 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Дүүргийн 39, 43 дугаар хороонд баригдаж буй 4,768.6 сая төсөвт өртөгтэй хорооны барилгын ажлын гүйцэтгээгүй ажилд гүйцэтгэл бичиж илүү санхүүжилт олгосон;
- Дүүргийн 8, 11, 28 дугаар хороонд хийгдсэн хороо, дүүргийн орчныг тохижуулах "Шинэ хороо" төслийн хүрээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ барилгын улаан дэвтэрт хяналт хэрэгжүүлсэн тэмдэглэгээ хийгээгүй, хяналт хэрэгжүүлсэн эсэх баримтаар нотлогдоогүй;
- "Шинэ хороо" төслийн зурагт өөрчлөлт оруулахгүйгээр зурагт тусгагдаагүй ажлыг гүйцэтгүүлсэн.

### **Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба:**

2023 онд 6,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ эрх шилжин хэрэгжсэнээс 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний гүйцэтгэгч гэрээ цуцалж 3 ТАХ хэрэгжиж дууссан.

Хэрэгжсэн 3 ТАХ-ний хүрээнд задгай тэвштэй хог тээврийн 15 авто машин, шахдаг тэвштэй хог тээврийн 10 авто машин нийт 25 авто машиныг "Бадрангуй-Орших"

ХХК 2021 оны 7 дугаар сарын 25-ний өдөр комисс ажиллуулан холбогдох байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, гэрээг 2023 оны 8 дугаар сарын 1-ний өдөр дүгнэжээ. Дээрх тээврийн хэрэгслүүд нь ашиглагч байгууллагын өмчлөлд шилжин ирснээс хойш нийт 332.12 сая төгрөгийг засвар үйлчилгээнд зарцуулсан бөгөөд үүний 134.0 сая төгрөгийг бараа, ажил үйлчилгээг хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх 1 жилийн хугацаанд эвдрэл гэмтэл гарч засварт хөрөнгө зарцуулсан байна.

ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй алдаа, зөрчлүүд нь хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудын мэдлэг чадвар, ажилд хандах хандлага, мэргэшсэн байх чадвартай шууд холбоотой байна.

УБЗАА-аас “Задгай болон шахдаг тэвштэй хог тээврийн машин” нийлүүлэх ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан холбогдох албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчил үүсгэж барьцаа хөрөнгийг чөлөөлж төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлээгүй *нөхцөл байдал илэрсэн тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу хууль хяналтын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлэхээр Монгол Улсын ерөнхий аудитор хандахаар шийдвэрлэлээ.*

**Дүгнэлт:** Зарим ТАХ-нд тавьсан захиалагчийн хяналт үр дүнгүй, бусад байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

### Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?

2023 онд бүрэн хэрэгжиж дууссан 49 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулахад 24,938.4 сая төгрөгийн 31 ТАХ буюу 63.3%-ийг өмч бүртгэлд тусган бүртгэж, 30,086.0 сая төгрөгийн 18 ТАХ буюу 36.7%-ийг өмч бүртгэлд тусгаагүй байна.

ХҮСНЭГТ№6 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАСАН ЭСЭХ

№	Ангилал	ТАХ-ний тоо	Гэрээний үнийн дүн	Бүртгэлд тусгасан ТАХ		Бүртгэлд тусгаагүй ТАХ	
				тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	Техник, тоног төхөөрөмж	26	12,669.44	20	11,364	6	1,305
2	Барилга	8	26,820.62	4	6,922	4	19,898
3	Тохижилт	15	15,534.32	7	6,652	8	8,882
	Нийт	49	55,024.38	31	24,938	18	30,086

ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь эцсийн санхүүжилт хүлээгдсэн, комиссын дүгнэлт гараагүй, ажлын эцсийн гүйцэтгэл гараагүй, ажил дууссан ч гэрээгээ дүгнээгүй зэргээс шалтгаалжээ. Тухайлбал:

- НХОГ ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгүүлэх хүсэлт илгээгүй 6 ТАХ-нээс санхүүжилт хүлээсэн 2 ТАХ, комиссын дүгнэлт гараагүй 1 ТАХ, шалтгаан тодорхойгүй 2 ТАХ, ажлын эцсийн гүйцэтгэл гараагүй 1 ТАХ;
- НЗХГ-ын 3 ТАХ-нээс ажлаас гэрээ дүгнээгүй 1 ТАХ, санхүүжилт хүлээсэн 1 ТАХ, бүртгэх шийдвэр тодорхойгүй 1 ТАХ;
- УБЗАА -ны 1 ТАХ хөрөнгө бүртгэх шийдвэр тодорхойгүй зэргээс бүртгэгдээгүй байна.



Эрх шилжсэн зарим ТАХ нь хөрөнгө оруулалтын бус шинж чанартай байгаагаас өмч бүртгэлд тусгах боломжгүйд хүрсэн байна. Тухайлбал:

- Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар СБД-ийн 7, 8, 10 дугаар хороо;
- Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар БГД-ийн СОТ 2-1, 9 дүгээр хороо 25 дугаар байрны 7 дугаар хороо, 4 дүгээр хороо, 05, 06, 07 дугаар байр, 5 дугаар хороо Эрэл 47/1, 47/2, 47/3 дугаар байр, 17 дугаар хороо Ганти 40, Ганти 40В дүгээр байр;
- ЧД-ийн орон сууцны фасадын дулаалга, дээврийн их засвар;
- СХД-ийн 12, 13, 14, 15, 16, 17 дугаар хороодод хийгдэх 7 ТАХ байна.

СХД-т хэрэгжсэн “Шинэ хороо” ТАХ-ний хүрээнд хорооллын зарим гудамжны айл өрхийн хашаа болон хаалгыг солих ажил хийгдсэн зэргээс шалтгаалж өмчид бүртгэгдэх боломжгүй болсон байна.

Цаашид УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-г батлахдаа өмчид бүртгэгдэх боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г тусгахгүй байх, хэрэв шаардлагатай гэж үзвэл нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг журмаар зохицуулах шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Үнийн индекс тооцсон, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г баталж хэрэгжүүлснээс шалтгаалж өмчид бүртгүүлэх ажил удаашралтай байна.

## В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

Барилга байгууламж, их засвар тохижилт хийх ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж харин тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-ний үр дүнд нийлүүлэгдсэн хөрөнгийн 70.4% нь ашиглалт хангалтгүй байна.

### В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?

2023 онд 60 ТАХ бүрэн болон хэсэгчлэн хэрэгжсэнээс барилга, байгууламж барих ТАХ 8, тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ 37, их засвар тохижилтын 15 ТАХ байна. ТАХ-ний үр дүнд үүссэн өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхийг ТАХ-ний ангилал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

#### Барилга байгууламж барих ТАХ:

11,608.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 км авто болон явган хүний замыг, гэрэлтүүлгийн хамтаар хийх 4 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 6.99 км авто замаас 6.45 км буюу 92.2%, 253 гэрэлтүүлэг хийхээс 224 гэрэлтүүлэг хийж 88.5%-тай гүйцэтгэлийг дүгнэж хүлээн авсан байна

Мөн 490 хүүхдийн ортой 3 цэцэрлэг, 1840 хүүхдийн суудалтай 2 сургуулийн барилга, БНД-т Ф325 мм ус хангамжийн шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил, 3.49 МВт дулаан хангамжийн ажлууд хийгдэж холбогдох байгууллагууд зориулалтын дагуу ашигласан байна.

#### Тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ:

2023 онд 430,841.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй тоног төхөөрөмж нийлүүлэх 40 ТАХ эрх шилжин ирснээс 37 ТАХ буюу 92.5% нь хэрэгжсэн байна. Үүнээс 25 ТАХ бүрэн, 12 ТАХ хэсэгчлэн хэрэгжиж ТАХ-ний үр дүнд 18617 нэр төрлийн техник, тоног төхөөрөмж, 900 нэр төрлийн тавилга, 190 тээврийн хэрэгсэл, 1660 компьютер, цахилгаан бараа нийлүүлэгдэж 3116.2 м<sup>2</sup> талбайд тавилга, хэрэгсэлтэй тохижилтын ажил хийгдсэн байна.

### ХҮСНЭГТ№7 ТАХ-НИЙ АШИГЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

№	ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгө	ТАХ-ний		Нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмж		Ашиглалтын байдал		/сая.төг/ Эвдэрч гэмтсэн Тоо хэмжээ
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Ашиглаж байгаа	Ашиглагдаагүй	
						Тоо хэмжээ	Тоо хэмжээ	
1	НБГ	9	7,993.9	18617	7,993.9	5497	13120	
2	ННТГ	2	409,878.8	190	409,878.8	170	20	
3	НЭМГ	16	4,772.1	458	4,772.1	408	50	
4	СХД	7	3,817.0	1221	3,817.0		1221	
5	УБЗАА	3	4,380.0	28	4,380.0	15	13	13
	<i>Дүн</i>	<b>37</b>	<b>430,841.8</b>	<b>20514</b>	<b>430,841.8</b>	<b>6090</b>	<b>14424</b>	<b>13</b>

ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн 29.6%-ийг зориулалтын дагуу ашиглаж, 70.4%-ийг ашиглаагүй байна.

Шалтгаан нөхцөлийг тодруулбал Нийслэлийн ЧД, СБД, СХД-үүдэд нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжийг барилгатай хамт төлөвлөж барилга ашиглалтад ороогүйн улмаас ашиглагдахгүй боломжгүйд хүрч хүлээгдсэн байна.

УБЗАА-нд нийлүүлэгдсэн 1,560.46 сая төгрөгийн үнийн дүнтэй хог тээврийн 13 авто машин эвдэрч зогссон, ННТГ-т газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн нийтийн тээврийн 20 автобус техникийн тодорхойлолтод нийцээгүйн улмаас тус тус ашиглалтгүй байна.

2023 онд их завсар, тохижилтын 14,571.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 15 ТАХ бүрэн хэрэгжиж зориулалтыг дагуу ашиглагдаж байна.

**Дүгнэлт:** ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн 70.4% нь ашиглалтгүй, 1,560.46 сая төгрөгийн хөрөнгө ашиглах боломжгүйд хүрч үр дүнгүй хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

## **В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?**

Хэрэгжиж дууссан ТАХ нь төлөвлөсөн үр дүнд хүрч хэрэгжсэн эсэхийг ТАХ-ний ангилал түр бүрээр авч үзэхэд:

### **Их засвар, тохижилт ТАХ:**

2023 онд их засвар, тохижилтын 17,882.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 15 ТАХ бүрэн хэрэгжсэн байна.

ТАХ-ний үр дүнд БГД, БЗД-ийн 8 дугаар хороонд 89 ширхэг гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн орон сууцуудад их засвар, БЗД-ийн 5 хороонд 39 ширхэг камержуулалд, СХД-т 240 өрхийн 4116м урт хашааны банзыг 205 өрхийн хашааны хаалганы хамт солих ажил хийгдсэн байна. Их засвар тохижилтоор хийсэн зарим ТАХ-ний үр дүн хангалтгүй, төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна Тухайлбал:

999.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй СХД-ийн 8, 11, 28 дугаар хороонд хэрэгжсэн хороо, дүүргийн орчныг тохижуулах "Шинэ хороо" төслөөр 240 өрхийн 4116м урт хашааны банзыг 205 өрхийн хашааны хаалганы хамт солих ажил хийгдсэн байна.

### **Зураг №11 УТХО-аар хийсэн тохижилтын ажил**



Хэрэгжилтийн байдлыг газар дээр нь очиж үзэхэд "Шинэ хороо" ТАХ-г цогц байдлаар шийдээгүй, хорооллын дунд эмх цэгцгүй байдлаар төлөвлөжээ.

Цаашид жишиг хороо гудамжны стандартыг баталж мөрдөх, энэ талаар арга хэмжээ авч хэрэгжих хүртэл жишиг хороо болон ижил төстэй ТАХ-г хэрэгжүүлэхгүй байх нь зүйтэй байна.

### **Техник, тоног төхөөрөмж ТАХ:**

2023 онд техник, тоног төхөөрөмж нийлүүлэх 37 ТАХ-ний үр дүнд 429,213.5 сая төгрөгийн үнийн дүнтэй 17,756 нэр төрлийн гал тогооны хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, 900 нэр төрлийн тавилга, 190 тээврийн хэрэгсэл, 1,660 нэр төрлийн компьютер, цахилгаан бараа нийлүүлэгдэж 3116.2 м<sup>2</sup> талбайд тавилга, хэрэгсэлтэй тохижилтын ажил хийгдсэн байна.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үр дүнгийн байдлыг тодруулахад дараах байдалтай байна.

- Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл шинэчлэлт 2 багц ТАХ-ний үр дүнд СХД-ийн 15 сургуульд 1,369.7 сая төгрөгийн үнийн дүнтэй 16269 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэхээс 13120 ширхгийг буюу 80.6% нь ашиглалтгүй;

- СХД-ийн 104 дүгээр сургууль нь 1007 ширхэг гал тогооны хэрэгслийг түрээслэгч байгууллагад ашиглуулсан;
- Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 12 ТАХ-ний үр дүнд СБД-ийн ЭМТ-ийн салбар амбулаторид 3542.1 сая төгрөгийн үнийн дүнтэй 290 нэр төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ЧД-ийн эрт илрүүлгийн төвд 19, нийт 309 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээс 16.2% нь ашиглалтгүй;
- СХД-ийн хүүхэд залуучуудын театрт 3,822.0 сая төгрөгийн үнийн дүнтэй 1221 нэр төрлийн техник, тоног төхөөрөмж, компьютер, цахилгаан хэрэгсэл нийлүүлэгдсэнээс 100% ашиглалтгүй;
- УБЗАА-с захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 5,078.8 сая төгрөгийн үнийн дүнтэй 3 ТАХ-ний үр дүнд нийлүүлэгдсэн 28 ширхэг ачаа тээврийн болон хог тээврийн авто машинаас 13 нь буюу 46.4% нь дахин ашиглах боломжгүйгээр эвдэрч зогссон байна.

Тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-ний үр дүнд бий болсон техник, тоног төхөөрөмж нь эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг сайжруулах тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж төлөвлөгдөж бүрэн хэмжээгээр нийлүүлэгдсэн ч төлөвлөсөн үр дүнд хүрч ашиглагдаагүй байна.

**Барилга байгууламж барих ТАХ:**

2023 онд 9545 хүүхдийн суудалтай 15 сургууль, 4060 хүүхдийн ортой 24 цэцэрлэг, 1660 хүүхдийн суудалтай бүхий бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 ортой оюутны дотуур байр барих нийт 46 ТАХ-г хэрэгжүүлэхээр эрх шилжүүлжээ.

Үүнээс 2023 онд 21,892.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-ний үр дүнд 1.11км авто зам, 0.02 км явган хүний зам, 490 хүүхдийн ортой 3 цэцэрлэг, 1840 хүүхдийн суудалтай 2 сургуулийн барилга, БНД-т Ф325 мм ус хангамжийн шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил, 3.49 МВт дулаан хангамжийн ажлууд хийгдэж зориулалтын дагуу ашиглагдаж үр дүнд хүрсэн байна.

**Дүгнэлт:** Тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ бүрэн хэрэгжсэн ч ашиглалтгүй үр дүн хангалтгүй, ТАХ-ний 21.6% нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаагүй байна.

---

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

---

**Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:**

1. Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.
2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зарим ТАХ-нд санхүүжилтийг зөрүүтэй олгожээ.
3. Хэрэгжсэн төсөл арга хэмжээний 36.7% нь өмчид бүртгэгдээгүй, 21.6% нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаагүй, тоног төхөөрөмж ашиглалтгүй, үр дүнгүй байна.
4. Барилга байгууламжтай хамт төлөвлөсөн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт 70.4% байна.

---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

---

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагаанд тогтмол хяналт хэрэгжүүлж, алдаа зөрчил гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцож хариу мэдэгдэх.

### **НЗХГ-т:**

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто замын барилга байгууламжийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль, журмыг баримтлан ажлын журналыг тогтмол хөтлөх, зөвлөх үйлчилгээ авах, ажлын тоо хэмжээг өөрчлөх тохиолдолд зохиогчтой заавал зөвшилцөж ажиллах.

### **НХОГ ОНӨААТҮГ-т:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах.

### **НӨХГ-т:**

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгуулах талаар арга хэмжээ авч ажиллах;
2. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, өмчид бүртгэгдэхгүй хөрөнгийг цаашид хэрхэн бүртгэх талаар журамд тусгуулах талаар холбогдох байгууллагуудад санал боловсруулан хүргүүлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.


# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Танай газраас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 747 дугаартай албан бичигтэй танилцлаа.

"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/18-11-ШТА-ГА) тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.



ДАРГА

Л.ХОСБАЯР

1110201832

Аудитын дүнлэлд өгөх тайлбар

№	Аудитын дүнлэл	Тайлбар
1	НХЗГ-аас захиалгачийн хяналт хэрэгжүүлсэн 10 дугуйн төсөвт өргөтгөлтэй 5 ТАХ-ээр нийтлэг 8 км авто зам, 0.8 км-ийг хүний зам, 0.8 км дугуйн зам, 78 ширхэг замын гэрлэлтүүг хийлгэсээр төлөвлөсөн 4.5 км авто зам, 0.35 км явган хүний зам, 0.3 км дугуйн зам, 49 ширхэг гэрлэлтүүгээр ажилтан тоо хэмжээг бууруулан хувиар авлаа. • Ривер Хилс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам, зогсоол, 1 км Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11 дугаар хороо, Гүйцэтгэгч: Даммодрүүд ХХК • Тосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зам хүртэлх хатуу хумигтай авто зам, 1 км Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, Гүйцэтгэгч: Баянболдтэй зам ХХК 17 ГНАГ-2024/18-ШТА-ГА • Хоргоолын доторх авто зам Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо, Гүйцэтгэгч: Тн Си Фэ ХХК • Хоргоолон доторх авто замын засвар Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5, 6, 7, 9 дугаар хороо, Гүйцэтгэгч: Голд-Билэнт ХХК • Хоргоолын авто замын шинэчлэл, өргөтгөл Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13, 14, 15 дугаар хороо, Гүйцэтгэгч: Голден Дрим ХХК	6.99 км авто зам хийгээс • 5.99 км авто зам бүрэн хийгдсэн • 1.0 км авто зам газар шалтгааны хийгдэж дууссагүй байна. 2. 13399 м2 талбай зам хийгээс • 11291 м2 явган зам хийгдсэн • 2108 м2 явган зам газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэж дууссагүй байна. 3. 800 м2 дугуйн замын ажил газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэж дууссагүй байна. 4. Тосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зам хүртэлх хатуу хумигтай авто зам, 1 км Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, Гүйцэтгэгч: Баянболдтэй зам ХХК 5. Ривер Хилс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам, зогсоол, 1 км Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11 дугаар хороо, Гүйцэтгэгч: Даммодрүүд ХХК - Ажил хэрэгжлээ өгөх акт эзэлсэн гаргаагүй байна.
2	Бариалын үйлдвэрлэлийн зохион байгуулалтын БНБД 12-01-09-ийн 6.11 Бариалын үйлдвэрлэлийн болтол амьдрал дараах аялууд хамаарна, газрын зөвшөөрөл авах, холбоо төсвийн нэмэлт авах, гэж хахууль баталсан үйлдвэрлэлээр болтол ажил хийгдээгүй төсөл, арга зохионоор зөргөөн ажилга 24 ГНАГ-2024/18-ШТА-ГА, ага хэмээх ажиллагааг дахин хөрөнгө төлөвлөж байгаа нь төлөвлөсөн хөрөнгө ашигдалтай байх нөхцөлөөн бүрдүүлж байна. Тухайлбал: • НХЗГ-аас хяналт хэрэгжүүлсэн 1,977.4 сая төгрөгийн төсөвт өргөтгөлтэй Дүүргийн	Нийслэлийн Засаг даргын захирамж болон Газрын дүрмийн дагуу Нийслэлийн Замын хөгжлийн газраас захиалгачийн хяналт хэрэгжүүлж байна.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/18-11-ШТА-ГА) тайлангай танилцаж, холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.



1110201832

№	Аудитын дүнлэл	Тайлбар
3	31ХС-ын 2018 оны 238 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн гэрлийн 1.21 Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалтын ажилт тэмцэж үйлчилгээг зөвөөр хэрэглүүлэх бөгөөд энэ үүрэг эрхгүй болгох" гэж зарласан ГЗНХЗ нь 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/009 дугаар захирамжийн хавсралтаар "Нийслэлийн Замын хөгжлийн газар"-ын дүрмийг батлах тус дүрмийн 4.15-ийн 4.1.3-д "Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, авто зам, замын байгууламжийн шинээр барьж, өргөтгөж, шинэчлэх, ашиглах, өрсөх хамгаалалтын ажил зохион байгуулах, захиалгачийн болон лабораторийн хяналт тэмцэж үйлчилгээг зөвөөр хэрэглүүлэх" гэж зарласны дагуу дараахыг хяналт хэрэгжүүлсэн нь дээрх зарчмыг зөрчилтэй илэрхийлж байна.	Хөрөнгө оруулалт нь Улсын төсвийн тухай хууль, Нийслэл дүүргийн Засаг даргын захирамжаар батлагддаг гүйцэтгэгч сонгож шалгаруулах үйл ажиллагаа явагдаж, барилгын ажлын гараа байгуулагдсаны дагуу захиалгачийн хяналт тэмцэж байна.
4	НХЗГ нь 2023 онд 7,353.2 сая төгрөгийн гэрлийн үнэм дүнгийн 5 ТАХ-ын захиалгачийн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөж, 6.99 км авто зам бүрэн хийгээс, 1.0 км авто зам газар чөлөөлөлтөөс шалтгааны хийгдэж дууссагүй байна. • 224 ш гэрлэлтүүг бүрэн хийгдэж дууссан. • 29 ш гэрлэлтүүг газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэж дууссагүй, хувиар авлаагүй байна. • Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас газар чөлөөлт хийгдэж болжээгүй гэж	6.99 км авто зам авто болон явган хүний замыг, 253 ш гэрлэлтүүг ажилгаар хийж 5 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 6.99 км авто зам бүрэн хийгдэж дууссан. • 1.0 км авто зам газар чөлөөлөлтөөс шалтгааны хийгдэж дууссагүй байна. • 224 ш гэрлэлтүүг бүрэн хийгдэж дууссан. • 29 ш гэрлэлтүүг газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэж дууссагүй, хувиар авлаагүй байна.
5	НХЗГ-аас газар зохион байгуулалтын албанаас газар чөлөөлт хийгдэж болжээгүй гэж	НХЗГ нь 2023 онд 7,353.2 сая төгрөгийн гэрлийн үнэм дүнгийн 5 ТАХ-ын захиалгачийн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөж, 6.99 км авто зам бүрэн хийгээс, 1.0 км авто зам газар чөлөөлөлтөөс шалтгааны хийгдэж дууссагүй байна. • 224 ш гэрлэлтүүг бүрэн хийгдэж дууссан. • 29 ш гэрлэлтүүг газар чөлөөлөлтөөс шалтгаалан хийгдэж дууссагүй, хувиар авлаагүй байна.

<ul style="list-style-type: none"> <li>хэрэгжүүлэхийг холбоотой дараах зарчмыг гаргасан байна. Үүнд:             <ul style="list-style-type: none"> <li>Зураг, төсөвт өөрчлөлт оруулах талаар зохиоготой зөвшөөрөл, ажлын тоо хэмжээг дур мэдэн бууруулж гэрээний үнийн дүнгээс хахаж тооцсон;</li> <li>Захиалгачийн хяналт хэрэгжүүлсэн талбайн журнал хөтөөгүй, хяналт хэрэгжүүлсэн бичиг тэмдэглэж ажлын талбар үйлддэггүй;</li> <li>Гүйцэтгэгч ажил хувиар гэх үүсгэлт өгч холбогдох засварыг хийгээсээр комиссоос үүрэг даалгавар өгсөн ч гүйцэтгэгчид холбогдох шаардлагыг тавьж ажил хүлээлцээгүй 1 жил үргэлжилсэн;</li> <li>Үр дүнгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөж гол болон туслах замтай холбогдох болжээгүй гудаж дунд зам барих ТАХ-г хэрэгжүүлэхээр батлалсан бичиг мөргөлийн бус хавдаж, үр дүнгүй хөрөнгө оруулалтыг дамжсан байна.</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>мадгадсан тул явган хүний зам дутуу хийгдсэн тоо хэмжээг гүйцэтгэгч хэсэг санхүүжүүлсэн.</li> <li>Захиалгачийн хяналтыг хэрэгжүүлэхдээ үе шатны ажлын зөвшөөрлийг тухай бүрт нь баталгаажуулж, өөр дугаарын ажлын тэмдэглээ хийж ажилласан;</li> <li>Гүйцэтгэгч байгууллагад комиссан үзгээ өгсөн үүрэг даалгаварыг дугаарын үйлбэлд хийж захиалгачтай тул хүйтний үйлбэрд ажил хийгдээгүй;</li> <li>Хөрөнгө оруулалт нь Улсын төсвийн тухай хууль, Нийслэл дүүргийн Засаг даргын захирамжаар батлагддаг гүйцэтгэгч сонгож шалгаруулах үйл ажиллагаа явагдаж, барилгын ажлын гараа байгуулагдсаны дагуу захиалгачийн хяналт тэмцэж ажиллаж байна.</li> </ul>
---	---

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАХИАЛГАЧЫН АЛБА ОНӨААТГ**  
Нутгийн захиргааны нэгдсэн байр, Баянголхон гудамж 1, 27 дугаар хороо, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18101  
Утас: (976) 7017 7880  
Цахим хуудас: info@sa.gov.mn

2024.04.16 № 176  
Тайм 2024.04.05 -ны № 741 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №741 дугаартай албан тоотын хавсралтаар ирүүлсэн "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/18-11-ШТА-ГА) тайланг хавсралтаар хүргүүлсэнтэй танилцан санал тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

Хөвснэв:  
НХЗГ-ын ЗБИВХХ-ийн дарга Т.Батбилэг  
Боловсруулсан:  
НХЗГ-ын ЗБИВХХ-ийн хяналтын мэргэжилтэн Д.Төрбилэг  
НХЗГ-ын ЗБИВХХ-ийн хяналтын мэргэжилтэн Ж.Эрдэнэ-Очир

НЭГ.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалттай "Хорооны барилга /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо" төсөл арга хэмжээний 4,768.6 сая төгрөгөөр гэрээг шинэчлэн батлаагүй, төсөвт суугаагүй ТАХ-ийн магадлагад үндэслэн анхны гэрээний дүнгээр бүтэн санхүүжилт олгосон. Гүйцэтгэл 50%-тай байхад 949.1 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон гэжээ.

Тайлбар:Уг төсөл арга хэмжээний тухайд бодит байдалаас зөрүүтэй хэд хэдэн шалтгаантай асуудлууд гарч байна нь. болно. Үүнд:

1.Аюулаас арга хэмжээний зарлагдаа жишиг зургаар түүхээр гаргуулах гэрээний нөхцөлөөр, гадна инженерийн шугам сулзгааны тухай барилганд зориулсан Төсвийн нөхцөлдүгй төндөрийг зарлаж байгаа нь уг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтэд шууд нөлөөлж байгаа ба энэ асуудал нь төлөвлөлтийн шатны алдааны улмаас, тухайлбал тухайн барилганд зориулан ажлын зурга төсвийг бүрэн гаргаж, магадлагаар баталгаажуулсан байх. Улсын төсвийн хөрөнгө оруулалтар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шаардлагыг зөрсөнөөр улмаас ийм байдалд хүрсэн гэж дүгнэж байна.

2.Мөн түүнчлэн УТХО-ын алмаас нэгэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн улсын төсөвт сууцлагдаа 2-3 он дамжуулан хөрөнгө хувааж тавих нь тухайн онд нь багтаж тавигдсан хөрөнгийг Сангийн яаманд татгуулахгүй байх шаардлагатай болдог, татгалдсан хөрөнгө төсөв батлагдах онд тавигдсан чадахгүй тохиолдолд бүр 2 жил дараа нь тавигдсан ирэх бас эрсдэл дагуулж байгааг хаа ханаа ойлгох гэж болсон байна.Энэ байдал нь дээрхи нөхцөл байдлыг үүсгэж нөлөөлж байна.

3.Тухайн 39,43 дугаар хороонд баригдах баригчуудын төсөвт өртөг бодит 2022 онд ч бодит байдал дээр 1 хорооны нутагн барилга 1.0 тэрбум төгрөгийн өртөгтэй байгаагүй бөгөөд цаашид Сангийн яаманд ч Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хөрөнгө батлуулахдаа тухайн төсөл, арга хэмжээнийг авчигч зурга төсөв батлуулан эсэх, магадлагаар батлагдсан хөрөнгөөр төлөвлөхөд анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.Төсвийн хөрөнгийг үр ашгийг, арвиан компаниутай зарцуулсан гэж дүгнэлтийн үндэслэл нь бодит байдалаас арай зөрүүтэй дүнхэлт болоод байна.

ХОЁР.

Аудитор НЭХГ, ННТГ, НХОГ ОНӨААТҮГ, СХД-ийн Захиалагчийн Алба ОНӨААТҮГ, УБЭАА-уудас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ-тай холбоотой дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- СХД-ийн Захиалагчийн Алба ОНӨААТҮГ:
• Дүүргийн 39,43 дугаар хороонд баригдах буй 4,768.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хорооны барилгын ажлын гүйцэтгэлийг ажилд гүйцэтгэл бичиж илүү санхүүжилт олгосон.

зугас төсөвт тусгагдаагүй ажил гүйцэтгүүлсэн.Тухай аудитын шалгалтын багт гүйцэтгэл болон манай зугас тодорхой тайлбар өгсөн.

ГУРАВ.Техник, тоног төхөөрөмж ТАХ:

- СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ:
• 3,822.0 сая төгрөгийн үнийн дүнгээ СХД-ийн Хүүхэд залуучуудын Театрт нийлүүлэгдэх 1221 нэр төрлийн техник тоног төхөөрөмж, компьютер, цахилгаан хэрэгсэл нь барилга байгууламж ашиглалтад ороогүйгээс 100% ашиглалтгүй гүйцэтгэлийн агуулахад хураалттай.

Тайлбар: Улсын төсвийн хөрөнгө оруулалттай СХД-ийн Хүүхэд залуучуудын театрт нийлүүлэгдэх техник тоног төхөөрөмжийг байрлуулах Хүүхэд залуучуудын театрын барилга нь өөрөө 2019-2024 он дамжин хэрэгжиж байгаа НХОГ захиалагчийн хяналт тавин ажиллаж барилга байгууламж бөгөөд уг барилгад 2024 оны 03 дугаар сарын 22-ний өдөр Хотын стандарт хяналтын газраас улсын комисс ажилласан. 2024 оны 04 дугаар сарын 03-ны өдрөөс ХЗТ-ын захиргаа уг барилгын хүлээн авч, дээрхи техник тоног төхөөрөмж, компьютер, цахилгаан хэрэгсэлийг бүх нийлүүлэгч байгуулагуудыг агуулахаас татан ашиглагч байгууллага суурилуулан хүлээлгэн өгч байгаа болно.

УТХО-ын техник тоног төхөөрөмж, компьютер, цахилгаан хэрэгсэлийн нийт 3,822.0 сая төгрөгийн үнийн дүнгээ 7 багцан нийлүүлэгч байгуулагын чандарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгө 24 сарын хугацаатай барьцаа хөрөнгийн диванд байршсан байгаа болно.

ДӨРӨВ.

Бусад байгуулагын хяналтын тухайд:

- Сонгинохайрхан дүүргийн дүүргийн нутаг давсагт 2022-2023 он дамжсан ба 2023 онд Утс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт болон Нийслэлийн орон нутгийг хөгжүүлэх сан, ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй бүх төсөл арга хэмжээнд Нийслэлийн Засаг Даргын А/242 тоот захирамж болон Дүүргийн Засаг даргын А/230 тоот захирамжаар батлагдсан Хотын стандарт хяналтын газартай хянгарсан ажлын хэсгийн "Стандартын хэрэгжилтүүлт хяналт"-ыг шалгах ажлын хэсгийн хяналт шалгалтанд бүх төсөл, арга хэмжээнийг хамруулан, тодорхой шаардлагауд өгсөнөөр дагуу засаг захиргаа, зөрчил голлолгүй арилган ажигласан.

гүйцэтгэлийн агуулахад хадгалсан тоног төхөөрөмжид анхаарч ашиглагчид хүлээлгэн өгөх талаар арга хэмжээ авч ажиллаж, гэж өөрчлөх саналыг хүргүүлж байна.

- Дүүргийн 8, 11, 28 дугаар хороонд хийгдсэн хороо дүүргийн орныг тохижуулах "Шинэ хороо" төсвийн хүрээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд барилгын улаан давтарг хяналт хэрэгжүүлсэн тэмдэглэгээ хийгээгүй, хяналт хэрэгжүүлсэн эсэх баримтаар нотлоогүй
• "Шинэ хороо" төсвийн зурга өөрчлөлт оруулахгүйгээр тусгагдаагүй ажил гүйцэтгүүлсэн.


Дүнхэлт: Зарим ТАХ-нд тавих захиалагчийн хяналт үр дүнгүй, өөр бусад байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй гэжээ.

Тайлбар:

1. Дүүргийн 39, 43 дугаар хорооны баригдах буй 4,768.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хорооны барилгын ажлын гүйцэтгэлийг ажилд гүйцэтгэл бичиж илүү санхүүжилт олгосон гэжээ. 39, 43 дугаар хорооны барилгын ажлын гүйцэтгэлийн тухайд гүйцэтгэлийг ажил гэдэг 39 дугаар хорооны барилгын хана, хавар ханан өргөмийн ажлыг газар дээрх фото актээр баталгаажуулан аудитад хүргүүлсэн. Тухайн 39, 43 дугаар хороонд баригдах баригчуудын төсөвт өртөг бодит 2022 онд ч бодит байдал дээр 1 хорооны нутагн барилга 1.0 тэрбум төгрөгийн өртөгтэй байгаагүй бөгөөд цаашид Сангийн яаманд ч Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хөрөнгө батлуулахдаа тухайн төсөл, арга хэмжээнийг авчигч зурга төсөв батлуулан эсэх, магадлагаар батлагдсан хөрөнгөөр төлөвлөхөд анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.Төсвийн хөрөнгийг үр ашгийг, арвиан компаниутай зарцуулсан гэж дүгнэлтийн үндэслэл нь бодит байдалаас арай зөрүүтэй дүнхэлт болоод байна.

2. Дүүргийн 8,11, 28 дугаар хороонд хийгдсэн хороо дүүргийн орныг тохижуулах "Шинэ хороо" төсвийн хүрээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд барилгын улаан давтарг хяналт хэрэгжүүлсэн тэмдэглэгээ хийгээгүй, хяналт хэрэгжүүлсэн эсэх баримтаар нотлоогүй гэсэн тухай уг төсөл, арга хэмжээнд хяналт тавьсан инженер нь гадаргаас явсан түл хяналтын хуудас нь Аудитын шалгалтын багт араас аюулсан болно. Мөн Барилгын ажлын улаан журманд бичигдсэн зүйлийг шалгуулсан. Хяналтын инженерийг нь ирээдүй бэй хяналтын хуудас нэмж хүргүүлсэн.

3. "Шинэ хороо" төсвийн зурга өөрчлөлт оруулахгүйгээр тусгагдаагүй ажил гүйцэтгүүлсэн гэжээ. Уг төсөл арга хэмжээний тухайд зурга өөрчлөлт оруулах шаардлага байгаагүй, хийгдсэн ажлууд бусад ажлын зургийн дагуу хийгдсэн. Зургаг тусгагдаагүй ажлуудыг гүйцэтгүүлсэн боловч БХБ-наас дараа төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт тусгагдсан "Магадлаагүй ажлын зардлыг олгохгүй" гэсэн чиг өгсөн улмаас ашиглан хороонд дара нарын шаардлага, болон комиссан шаардлын өгсөн зурга давталгаар хянгарсан түл нэмэлтээр тодорхой эзэн ажил хийгдсэн нь төсөв өртөгт тусгагдаагүй ажлууд болно. Төсөв өртөгт тусгагд нэмэлт ажил гаж оруулж болох байсан боловч уг төсөл арга хэмжээний УТХО-д 2022 онд тавигдсан 60.0 жаран сая төгрөгийн хөрөнгө оны цэцэр Сангийн яамнаас "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ" гэсэн албан тооллоор Төсвийн өргөмжлөл зарварч БХБ-наас 2022 оны эцэст татагдаж байсан түл ийм төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн



"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг" д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангай танилцуулга.

Тайлангийн дараах хэсгүүдэд:

- 1. Тайлангийн Хүснэгт №18 нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмж Нийслэлийн Эрүүл мэндийн газар:

3,542.1 сая төгрөгийн үнийн дүнгээ 12 ТАХ-ийн хүрээнд СБД-ийн ЭМТ-ийн салбар амбулаторид 290 нэр төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ЧД-ийн эрт илрүүлгийн төвд нийлүүлэгдэх 19, нийт 309 нэр төрлийн тоног төхөөрөмжөөс 16.2%-ийг ашиглаагүй, зориулалтын бус агуулах, амалгийн коридорд хадгалсан. Санал: 3,542.1 сая төгрөгийн үнийн дүнгээ 12 ТАХ-ийн хүрээнд СБД-ийн ЭМТ-ийн салбар амбулаторид 290 нэр төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ЧД-ийн эрт илрүүлгийн төвд нийлүүлэгдэх 19, нийт 309 нэр төрлийн тоног төхөөрөмжөөс 16.2%-ийг амалгийн шинэ барилга ашиглалтад ороогүйн улмаас ашиглаагүй, зориулалтын бус агуулах, амалгийн коридорд хадгалсан.

- 2. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ-НЭМГ болон СХД-ийн барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-уудад:

Барилга байгууламжтай хамт төлөвлөгдсөн тоног төхөөрөмжийг барилга байгууламж ашиглалтад орох хуртат барьцаа хөрөнгийг чөлөөлөхгүй байх, зориулалтын бус газарт хадгалсан болон гүйцэтгэлийн агуулахад хадгалсан тоног төхөөрөмжид анхаарч ашиглагчид хүлээлгэн өгөх талаар арга хэмжээ авч амжилгаж;

Санал: Барилга байгууламжтай хамт төлөвлөгдсөн тоног төхөөрөмжийг барилга байгууламж ашиглалтад орох хуртат ашиглаагүй тоног төхөөрөмжийн барьцаа хөрөнгийг чөлөөлөхгүй байх, зориулалтын бус газарт хадгалсан болон



---

## САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

---

УБЗАА, НХААГ, НӨХГ, “НХОГ” ОНӨААТҮГ-аас аудитын тайлангийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй.

НЗДТГ-аас 2024 оны 04 сарын 11-ний 03/1934 дугаар албан бичгээр тайлангийн төсөлтэй танилцаж тусгайлан өгөх саналгүйгээ илэрхийлсэн.

НЭМГ, СХД-ийн захиалагчийн хяналтын албанаас ирсэн саналууд нь аудитын явцад хүлээн зөвшөөрсөн зөрчлүүдтэй холбоотой тул аудитын тайланд тусгах боломжгүй байна.

НЗХГ-аас 2024 оны 04 сарын 15-ны 01/755 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг хүлээн авч холбогдох засвар хийсэн.

## Зөрчилтэй ТАХ-ний мэдээлэл

Д/д	ТАХ-ний нэр	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага	Эхлэх огноо	Дуусах огноо	Төсөвт өртөг	/сая.төг/
						Санхүүжих дүн
1	Нийтийн тээврийн автобус /УБ/	ННТГ	2023	2023	134,561.4	134,561.4
2	Хорооны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо/	СХД	2022	2024	1,898.1	898.1
3	Ривер Хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам, зогсоол, 1 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо/	НЗХГ	2019	2023	1,575.0	95.2
4	Тоосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зах хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо/	НЗХГ	2020	2023	1,599.3	99.3
5	Хорооллын доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо/	НЗХГ	2020	2023	976.7	28.0
6	Хороолол доторх авто замын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5, 6, 7, 9 дүгээр хороо/	НЗХГ	2020	2023	4,366.1	136.1
7	Хорооллын авто замын шинэчлэл, өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13, 14, 15 дугаар хороо/	НЗХГ	2020	2023	2,091.6	117.2
8	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	НХОГ	2020	2024	4,297.5	297.5
9	Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/	НХОГ	2021	2024	8,576.9	2,000.0
10	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	НХОГ	2023	2023	967.7	870.4
11	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 19 дүгээр хороо/	НХОГ	2018	2023	4,950.0	942.8
12	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	НХОГ	2018	2023	7,145.5	1,547.0

13	Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/	НХОГ	2019	2024	7,593.9	977.2
14	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/	НХОГ	2020	2023	7,853.3	2,419.8
15	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/	НХОГ	2018	2023	5,762.3	1,138.8
16	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	НХОГ	2022	2023	1,520.9	1,020.9
17	Нийтийн тээврийн автопаркийн гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	НХОГ	2023	2024	7,626.7	7,626.7
18	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	НХОГ	2023	2023	37,896.4	37,896.4
19	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороо/	НХОГ	2022	2023	2,000.0	1,873.3
20	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай АШҮН 26 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна ус хангамж, ариутгах татуурга, холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил /ХУД, 3 дугаар хороо/	НХОГ	2021	2023	541.2	541.2
21	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 6, 7, 8 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /БЗД, 16 дугаар хороо/	НХОГ	2020	2023	629.4	209.5
22	Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	НХОГ	2019	2024	4,183.9	183.9
23	Ус зайлуулах суваг, шугам /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Нарны хороолол-Дунд гол/	НХОГ	2020	2023	350.0	250.0
24	Найрамдал төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн	НХОГ	2022	2023	241.0	181.0

	гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1, 3, 4 дүгээр хороо/					
25	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль/	НХОГ	2022	2023	2,558.3	2,321.3
26	Хороо, дүүргийн орчныг сайжруулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2, 19, 24 дүгээр хороо/	НХОГ	2022	2023	3,980.0	3,080.0
27	Багануур хотын ус хангамжийн шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил	НХОГ	2023	2023	2,000.0	2,000.0
28	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Гангар инвест/	НХОГ	2019	2023	4,279.6	806.8
29	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/	НХОГ	2022	2025	10,197.3	7,157.0
30	Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	НХОГ	2022	2023	1,000.0	1,000.0